



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A/26

Улаанбаатар хот

### Г Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" 2018 оны А/652 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гоёлтан" ХХК-тай байгуулсан "Чингэлтэй дүүрэгт хог хаягдал тээвэрлэх зориулалт бүхий автомашин нийлүүлэх" НХААГ/18/0072-2 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй автомашиныг нийслэлийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
2. Хог тээвэрлэх зориулалт бүхий автомашиныг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу актаар хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг Ажлыг хэсэг /М.Энхболд/-т, хүлээн авч буй хөрөнгийн бичиг баримтын бүрдлийг ханган холбогдох журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Ариунбаатар/-д үүрэг болгосугай.


ДАРГА

Ч.ОДНАСАН



115050000091

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2019 оны 01 дугаар сарын 13. -ны  
өдрийн 2019 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн  
ахлагч:

М.Энхболд

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
Өмчийн төлөөлөл, менежмент,  
хувьчлалын хэлтсийн дарга

Гишүүд:

Ч.Цогтбаяр

Чингэлтэй дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний  
албаны дарга

Б.Эрдэнэбаяр

Чингэлтэй дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Тохижилт нийтийн аж  
ахуйн хэлтсийн мэргэжилтэн

Д.Амарбаясгалан

Чингэлтэй дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Санхүү, төрийн сангийн  
хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга:

Б.Батаа

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
Өмчийн төлөөлөл, менежмент,  
хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн